





Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ БИЙ БОЛГОН, БИЧИЛ
УУРХАЙГ ДЭМЖИЖ, ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙГ ИРГЭДИЙН НӨХӨРЛӨЛИЙН
ОРОЛЦООТОЙГООР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХЭЭР БАЙНА.**



**АУДИТЫН СЭДЭВ: УУЛ УУРХАЙН
АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ,
АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН
ХЭРЭГЖИЛТ**



2021 ОН



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН 11 ХУВЬ, ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН 18 ХУВЬ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙНА.....6

1.1 Аймгийн засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр тавьсан зорилгыг 88 хувьтай биелсэн гэж дүгнэжээ.....	6
1.2 Нутгийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж ажиллахаар байна.....	7
1.3 Аймагт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нэгж талбар байхгүй, хууль зөрчиж төлбөр ногдуулж байна.....	9
1.4 Аймгийн хэмжээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гарсан 1 нэгж талбай байна.....	10

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛУУЛДАГГҮЙ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН ИРҮҮЛДЭГГҮЙ, БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ДАНСАНД БАЙРШУУЛСАН МӨНГИЙГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИД БУЦААН ОЛГООГҮЙ ЗӨРЧИЛ БАЙСААР БАЙНА.....12

2.1 Уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэн дүгнэлт өгчээ.....	12
2.2 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2018-2020 онд давхардсан тоогоор 306 лиценз эзэмшигч менежментийн төлөвлөгөө батлуулаагүй, 87 лиценз эзэмшигч нөхөн сэргээлтийн тайлан ирүүлж дүгнүүлээгүй байна.....	13
2.3 Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэлд тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан лиценз эзэмшигчийн 109,103.6 мянган төгрөгийн үлдэгдэл байна.....	15

БҮЛЭГ 3. УУЛ УУРХАЙН САЛБАРТ ЗӨРЧИГДӨЖ БАЙГАА АСУУДЛЫГ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ШИЙДВЭРЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХААР БАЙНА.....18

3.1 Орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байна.....	18
3.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь хуулийн дагуу үүргээ биелүүлж ажиллахгүй байна.....	19
3.3 Аймгийн хэмжээнд хууль бус олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 9 сумын 50 нэгж талбарт 159.4 га газар байна.....	20
3.4 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 42 талбайн 14,948.1 га нь усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилд давхцалтай, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 9 талбайн 33,269.5 га нь орон нутгийн тусгай хамгаалалтай газартай давхцалтай байна.....	22
3.5 Улсын нөөцөд авсан газраас зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал болон түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөцийг олборлож байна.....	22

Холбогдох байгууллагын санал:	26
Саналд өгсөн тайлбар:	27
ДҮГНЭЛТ:.....	25
ЗӨВЛӨМЖ:	25



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХҮСНЭГТЭН ТОВЬЁГ

№	Хүснэгтийн нэр	Хуудас
Хүснэгт 1	Уул уурхайн ашиглалт хайгуулын зөвшөөрөл эзэмшигчдээс 2018-2021 онд өгсөн хандив	8
Хүснэгт 2	Бичил уурхайчдын нөхөн сэргээсэн газрын мэдээлэл	11
Хүснэгт 3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	13
Хүснэгт 4	Нөхөн сэргээлт	14
Хүснэгт 5	Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн судалгаа	15
Хүснэгт 6	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	15
Хүснэгт 7	Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансны бүртгэл	17
Хүснэгт 8	Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын судалгаа	19
Хүснэгт 8	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлт	20
Хүснэгт 10	Хууль бус олборлогчдын үйл ажиллагаанаас эвдрэлд орж орхигдсон газрын нөхөн сэргээлт	20
Хүснэгт 11	Хууль бус олборлогчдын үйл ажиллагаанаас эвдрэлд орж орхигдсон газар	21
Хүснэгт 12	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газрын давхцал	22

ЗУРГИЙН ТОВЬЁГ

№	Зургийн нэр	Хуудас
Зураг 1	Хууль бус ашигт малтмалын олборлолтод хийсэн хяналт	11
Зураг 2	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан карьерын нөхөн сэргээлт 52.77 га	14
Зураг 3	Хууль бус ашигт малтмал олборлох зөрчлийг арилгуулах арга хэмжээ	20

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Дүрслэлийн нэр	Хуудас
Дүрслэл 1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл /2021.05 сарын байдлаар/	5
Дүрслэл 2	Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо 2018-2020 он	14
Дүрслэл 3	Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, сумдаар	14



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан сэдэв, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн “Уул уурхайн ашигт малтмалын хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн хэрэгжилт”-д хийх аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	Уул уурхайн ашигт малтмалын хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтэд аудит хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➢ Уул уурхайн ашигт малтмалын хайгуул, ашиглалт үр дүнтэй эсэх ➢ Уул уурхайн нөхөн сэргээлтийн хэрэгжилт үр дүнтэй эсэх ➢ Орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн ЗДТГ, сумдын ЗДТГ, бусад холбогдох байгууллага, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын хяналт тавьж стандартыг хангуулан, ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитор Г.Энхдэлгэр, аудитор С.Санчирмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитыг 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл гүйцэтгэсэн.
Хүндрэл бэрхшээл	Ковид цар тахлын улмаас хөл хорио тогтоосноор сумдад ажиллаагүй болно. Аудиттай холбоотой баримт материалыг цахимаар авч аудитыг гүйцэтгэсэн нь гүйцэтгэлийн шатанд хүндрэл бэрхшээлтэй байлаа. Мөн аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн ажлаас гарсан тул аудиттай холбоотой мэдээллээр бүрэн хангагдсангүй.




ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ


Говь-Алтай аймгийн нийт нутаг дэвсгэр 141.4 мянган км². Нийт газар нутгийн 53.9 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад хамрагдсан.

Газрын нэгдмэл сангийн ангилал:

Он	Хөдөө аж ахуйн газар	Хот тосгон бусад суурин газар	Зам шугам сүлжээний газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Тусгай хэрэгцээний газар	Нийт дүн
2018	8346.5	18.0	7.6	1221.2	14.2	4537.2	14144.7
2019	7985.9	18.1	7.6	1221.2	14.2	4897.7	14144.7
2020	8620.8	18.3	7.6	1221.2	14.2	4262.3	14144.7



Говь-Алтай аймгийн уул уурхайн салбарын ерөнхий мэдээлэл




Говь-Алтай аймагт 93 орд, 701 гаруй илрэлүүд мэдэгдээд байна. Геологийн судалгааны хувьд 1959-1960-аад оноос эхэлсэн ба 1:200000 масштабтай геологийн зураглалаар 100 хувь бүрхэгдсэн, 1:50000 масштабтай геологийн зураглалын ажилд газар нутгийн 30 орчим хувь нь хамрагдаад байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газраас гаргасан 2020 оны 12 сарын эрдэс баялгийн статистик мэдээнд мэдээлснээр Говь-Алтай аймагт:

- ✓ Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй 139 аж ахуйн нэгж байгууллага 596.9 мянган га газарт хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулжээ. Үүнээс 92.2 мянган га газарт 55 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 504.6 мянган га газарт 84 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Талбайн хэмжээ нь нийт нутаг дэвсгэрийн 4.2 хувийг эзэлж байна.
- ✓ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гаргасан 5.71 га газрын 1 тусгай зөвшөөрөл олгосон.
- ✓ Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 4 баяжуулах үйлдвэр 10.9 га газарт уулын ажилд хамрагдан 2.9 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж 3.6 га газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны 05 дугаар сарын байдлаар ашигт малтмалын хүчин төгөлдөр 134 тусгай зөвшөөрөл байна.



Дүрслэл-1 Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл /2021.05 сарын байдлаар/



- ✓ Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй 139 аж ахуйн нэгж байгууллага 618.2 мянган га газарт хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулжээ. Үүнээс 102.4 мянган га газарт 55 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 515.8 мянган га газарт 79 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Талбайн хэмжээ нь нийт нутаг дэвсгэрийн 4.2 хувийг эзэлж байна.



БҮЛЭГ 1: Уул уурхайн ашигт малтмалын хайгуул, ашиглалт үр дүнтэй эсэх

**АЙМГИЙН ХЭМЖЭЭНД АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИЙН 11 ХУВЬ, ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИЙН 18 ХУВЬ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙНА.**

1.1 Аймгаас эрдэс баялгийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх

1.1 Аймгийн засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр тавьсан зорилгыг 88 хувьтай биелсэн гэж дүгнэжээ.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт "Хариуцлагатай уул уурхайг бий болгон, бичил уурхайг дэмжиж, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг иргэдийн нөхөрлөлийн оролцоотойгоор хийж гүйцэтгүүлнэ" гэсэн зорилго тавьж ажиллажээ. Үүнд:

- ✓ 4.4.1-т "Гар аргаар алт олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, бичил уурхайгаар олборлолт явуулан, өрхийн орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжиж, хууль бусаар ашигт малтмал олборлох явдлыг таслан зогсооно"
- ✓ 4.4.2-т "Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж хамтран ажиллана"

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн биелэлтийг гарган хэрэгжилт 88 хувьтай байна. Үүнд:

- ✓ Хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэдийг Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын дагуу зохион байгуулалтад орсон 1 холбоо, 9 төрийн бус байгууллага бүртгэгдэж, 24 бүртгэгдээгүй нөхөрлөлийн 300 гаруй бичил уурхайчид нэгдсэн зохион байгуулалтад ороод байна".
- ✓ 2017-2020 онд Алтай сумын Торготын нуруунд "Алтайн бичил уурхайчдын эв нэгдлийн холбооны гишүүн 6 нөхөрлөл, "Аж ариун ундрал" ТББ-ын 4 нөхөрлөл, нийт 85 бичил уурхайчид үйл ажиллагаа явуулжээ.
- ✓ 2019 онд Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Тогтвортой бичил уурхай" төслийн хүрээнд аймгийн хэмжээнд хууль бус ашигт малтмал олборлогч иргэдийг зохион байгуулалтад оруулж 2 нөхөрлөлийг байгуулж, 31 бичил уурхай эрхлэгчийг оёдолчин, үсчин, хүнд машин механизмын операторын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, мэргэжлийн үнэмлэх олгосон байна.
- ✓ Мөн "Бичил уурхайн эрх зүйн орчин, түүний хэрэгжилт, тулгамдаж буй асуудлууд" сэдэвт зөвлөгөөнийг 2018 онд зохион байгуулж, төрийн байгууллага, бичил уурхайн чиглэлээр байгуулагдсан холбоо, ТББ, хоршоо, нөхөрлөлүүдийн төлөөлөл нийт 110 хүн оролцсон байна.
- ✓ Аймгийн хэмжээнд ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 6 уурхай байгаагаас "Мандал-Алтай групп" ХХК-ийн Хөв булгийн нүүрсний, "Гоби коулд энд энержи" ХХК-ийн Зээгтийн нүүрсний, "Алтайн Хүдэр" ХХК-ийн Таяннуурын төмрийн хүдрийн уурхай, "Болдгянтболд" ХХК-ийн "Зүүн сайр"-ын алтны шороон орд, "Эн Си Жи Ти" ХХК-ийн Хуурайн алтны шороон орд, "Цогц эрин транс" ХХК-ийн Бөөрөгийн алтны шороон орды уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналтыг жил бүрийн 6, 9-р сард хийж зөвлөмж чиглэл өгч ажиллажээ.
- ✓ 2020 онд Цогт, Эрдэнэ, Цээл, Бугат, Төгрөг, Тонхил, Халиун, Бигэр, Есөнбулаг, Тайшир, Шарга, Дэлгэр гэсэн 13 сумд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 6, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 37 талбайд үйл ажиллагаа явуулах 29 ААН, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 3 ААН-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан бүртгэж үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх дансанд 13.6 сая төгрөг байршуулжээ.
- ✓ 2017-2019 онд ашиглалтад орсон "Цогц эрин Транс" ХХК, "Болдгянтболд" ХХК-ийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах уурхайнууд нь дэд бүтцийн асуудлаа хувийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн байна.
- ✓ 2016-2018 онуудад Чандмань сумд ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа "Гоби-Ковулд энд Энержи" ХХК, Цээл сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа "Алтайн Хүдэр" ХХК болон хайгуулын үйл ажиллагаа явуулж буй 3 аж ахуйн нэгж тухайн сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллалаа. Аймгийн хэмжээнд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийхээр төлөвлөн, 2019 оны 12 дугаар сард төр, хувийн хэвшлийн 2 талт хамтын уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, гэрээний төслийг эцэслэсэн бөгөөд 2020 онд тус гэрээг баталгаажуулахаар төлөвлөсөн боловч Ковид-19 цар тахлын улмаас баталгаажуулах боломжгүй болсон байна.



- ✓ Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 36 өргөдөл ирснийг журмын дагуу шийдвэрлэн, Халиун, Бугат, Алтай сумдад хайгуулын 4 тусгай зөвшөөрлийг олголоо. Алтай хотын барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Есөнбулаг сумын нутагт орших түгээмэл тархацтай ашигт малтмалын илрэл бүхий 4 газрыг Улсын нөөц газрын давхцалаас гаргах хүсэлтийг УУХҮЯ-нд хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020-2025 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.3-т. Уул уурхайн чиглэлээр “Ашигт малтмалын томоохон ордуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ” гэсэн зорилго тавьжээ. Үүнд:

- ✓ 3.1-т “Тайшир сумын нутагт орших шохойн чулууны Дөрвөлжингийн ордыг түшиглэн жилд 360 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг байгуулж, төмрийн хүдрийн ордыг түшиглэн төмрийн хүдэр баяжуулах, экспортлох төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.”
- ✓ 3.3.2-т “Түгээмэл тархацтай ашигт малтмалын илрэлийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, орд, илэрцийн мэдээллийн санг үүсгэж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нөөцийг тогтоон, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлнэ”
- ✓ 3.3.3-т “Хууль бус ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн, ашиглах боломжтой газруудыг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авч, бичил уурхай эрхлэгчдийг дэмжинэ.”


1.2 Уул уурхайн ашигт малтмалын хайгуул, ашиглалт үр дүнтэй эсэх

1.2 Нутгийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж ажиллахаар байна.

Уул уурхайн салбар нь 2020 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 22 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 71 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 71 хувь, экспортын 94 хувийг тус тус бүрдүүлжээ. Тухайн жил Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлээр 10.4 их наяд төгрөгт хүрч 2019 оны мөн үеэс 1.6 их наяд төгрөг буюу 13.6 хувиар буурсан. Үүнээс эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 2,673.3 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 246.6 тэрбум төгрөг буюу 8.4 хувиар буурсанд КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал нөлөөлжээ. /эх үүсвэр: Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яамны мэдээллээс/

Мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл ахиу олгосон, уул уурхайн олборлолт боловсруулалтын салбар хөгжсөн сумдад ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 100 хувийг, ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50 хувийг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгчийн төлсөн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувийг тус тус шууд орлогоор “Орон нутгийн хөгжлийн сан”-д хуваарилж байна.

Аймгийн хэмжээнд ашиглалтын үйл ажиллагааг 13 талбайд 6 аж ахуйн нэгж байгууллага явуулж байна.



Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь нийгмийн дэмжлэг, хөрөнгө оруулагчдын итгэлцэл дээр тогтдог. Тиймээс салбарын бодлогыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах, тогтвортой байлгах, ил тод байдлыг хангах, иргэд олон нийтэд зөв ойлголт өгч, бүх түвшинд нээлттэй хамтран ажиллах нь чухал юм.

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1¹-т заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллахаар хуульчилсан.

Сумдын Засаг дарга нар нь зарим тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллажээ. Үүнд:

- ✓ Алтай сум нь 2018, 2019 онд “Өү Жи Си Эйч Эл” ХХК, “Эф Ви Эс Пи” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан биелэлтийг дүгнэж ажилласан байна.
- ✓ Бигэр сум нь 2019 онд “Эн Си Жи Ти” ХХК-тай гэрээ байгуулан, гэрээг дүгнэж ажиллажээ.
- ✓ Тайшир сум нь 2018 онд Тайширын хүдэр ХХК-тай, 2020, 2021 онд “Цэн газар” ХХК-тай гэрээ байгуулан, гэрээг дүгнэж ажилласан.
- ✓ Цээл сум нь 2018 онд “Алтайн хүдэр” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гэрээг дүгнээгүй байна.
- ✓ Цогт сум нь 2021 онд “Ханхэнтийн хүдэр” ХХК-тай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна.

Гэвч бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж ажиллаагүй байна.

Хүснэгт-1 Уул уурхайн ашиглалт хайгуулын зөвшөөрөл эзэмшигчдээс 2018-2021 онд өгсөн хандив /мянган.төгрөг/

Сум	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Нутгийн захиргааны байгууллага		Аж ахуйн нэгж байгууллага		Хувь хүн		Нийт дүн
		мөнгөн	мөнгөн бус	мөнгөн	мөнгөн бус	мөнгөн	мөнгөн бус	
Ашиглалтын зөвшөөрөлтэй ААНБ-аас өгсөн хандив								
Алтай	Эф Ви Эс Пи, Өү Жи Си Эйч Эл	43,000.0						43,000.0
Бигэр	Эн Си Жи Ти, Марко Поло		15,000.0	97,000.0		3,000.0		115,000.0
Есөнбулаг	Болд гянт болд ХХК, Марко Поло		72,900.0				51,800.0	124,700.0
Тайшир	Цэнгазар		20,000.0				1,464.0	21,464.0
Төгрөг	Хүннү Алтай минериалс	5,000.0					7,000.0	12,000.0
Цээл	Алтайн хүдэр	38,013.0	109,000.0	27,000.0		1,710.0		175,723.0
Эрдэнэ	Налгархөндий		2,000.0					2,000.0
ДҮН/ АТЗ		86,013.0	218,900.0	124,000.0	-	4,710.0	60,264.0	493,887.0
Хайгуулын зөвшөөрөлтэй ААНБ-аас өгсөн хандивын дүн								
Бигэр	Металл эрэл хайгуул		38,000.0					38,000.0
Дэлгэр	Глобалбальш	1,000.0						1,000.0
Цогт	Анаэль, Эрдэнэ Монгол, Металл опт, Хүрэмтийн хяр	13,955.3						13,955.3
Эрдэнэ	Голден хаммер, Хүрэмтийн хяр, Улз групп		6,000.0					6,000.0
ДҮН/ ХТЗ		14,955.3	44,000.0	-	-	-	-	58,955.3
НИЙТ ДҮН		100,968.3	262,900.0	124,000.0	-	4,710.0	60,264.0	552,842.3

Эх сурвалж: Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Дээрх судалгаанаас үзэхэд уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс нутгийн захиргааны болон бусад байгууллага, иргэдэд 2018 оноос 2021 оны хооронд нийт 552,842.3 мянган төгрөгийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг бий болгосон байна. [/Дэлгэрэнгүйг хавсралт-2/](#)

¹ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.



Улсын хэмжээнд уул уурхайн салбарт баримталж байгаа бодлогын тухайд:

- ✓ Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах
- ✓ Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах замаар хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх
- ✓ Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахгүй, орон нутагт хамтарч ажиллахгүй байгаа уул уурхайн тусгай зөвшөөрлийг цуцлах

Аймгийн зүгээс уул уурхайн салбарт баримталж буй бодлогын тухайд:

- ✓ Уул уурхай, байгаль орчны салбарт төрөөс баримталж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- ✓ Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах замаар хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.
- ✓ Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагуудтай Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 дэх хэсгийг үндэслэн хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана.
- ✓ Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахгүй, орон нутагтай хамтран ажиллахгүй байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын тусгай зөвшөөрлийн цуцлах ажлыг зохион байгуулна.
- ✓ Орон нутгийн түвшинд төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулна.

Иймээс нутгийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар “нийгмийн хариуцлагын гэрээ” байгуулан ажиллаж, жил бүр гэрээгээ дүгнэж ажиллах нь зүйтэй юм.

1.3 Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа үр нөлөөтэй эсэх

1.3 Аймагт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нэгж талбар байхгүй, хууль зөрчиж төлбөр ногдуулж байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийн талаар:

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11.2.5²-д заасны дагуу аймгийн Засаг дарга Алтай, Бугат, Халиун, Бигэр сумын нутаг дэвсгэрт хамаарах 2,067.5 га газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 6 зөвшөөрлийг 4 аж ахуйн нэгжид олгосон байна. Үүнд:

- ✓ “Далд чулуу” ХХК-д 2018 онд Бугат сумын Хайчийн хөндийд 304.25 га, Алтай сумын Цагаан тэмээтэд 213.5 га газрын түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын зөвшөөрлийг олгосон.
- ✓ “Мөнгөн хүү амжилт” ХХК-д 2018 онд Халиун сумын 2 нэгж талбарт 791.4 га газрын түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын зөвшөөрлийг олгосон.
- ✓ “Эрдэнэт Залуур” ХХК-д 2017 онд Бигэр сумын Хулморьтод 399.3 га газрын түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын зөвшөөрлийг олгосон.
- ✓ “Ти эм жи эс” ХХК-д 2016 онд Бугат сумын Хар сайрт 359.0 га газрын түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын зөвшөөрлийг олгосон байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 23.1³-т заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.6.1⁴-т заасны дагуу жил бүр төлөхөөр хуульчилсан. Гэвч түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нийт 1,599.6 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж төлсөн нь тодорхойгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт-3/

² харьяалах нутаг дэвсгэрт нь хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;

³ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.6-д заасны дагуу жил бүр төлнө.

⁴ түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 100 төгрөг, хоёр дахь жилд 200 төгрөг, гурав дахь жилд 300 төгрөг, дөрвөөс тав дахь жилд тус бүр 1000 төгрөг;



Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн талаар:

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 33.1⁵-т түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлөхөөр байна.

Говь-Алтай аймагт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдоогүй боловч сумдын орон нутгийн төсөвт 2018 онд 15,313.6 мянган төгрөгийн, 2019 онд 23,952.7 мянган төгрөгийн, 2020 онд 19,301.5 мянган төгрөгийн түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төвлөрүүлжээ.

Энэ нь сум орон нутагт барилга, байгууламж, зам, гүүр барихтай холбогдуулан элс, хайрга гэх мэт түгээмэл тархацтай ашигт малтмалын хэрэгцээ зайлшгүй гарч байгаа бөгөөд гүйцэтгэгч компани нь ашигт малтмалыг сумын нутаг дэвсгэрээс олборлож авч байгаа нь хууль бодит амьдралд мөрдөгдөх нөхцөл бүрдээгүйтэй холбоотой. Сумын татварын байцаагчид зайлшгүй шаардлагаар түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас төсөвт төлөвлөсөн дүнгээр төлбөр ногдуулж орон нутгийн орлогыг бүрдүүлж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 36 дугаар тогтоолоор Есөнбулаг сумын нутаг дахь барилгын үйлдвэрлэлийн ач холбогдолтой түгээмэл тархацтай ашигт малтмалын /элс, хайрга, дайрга, шавар/ илэрцүүд бүхий газрууд улсын нөөцөд авсан талбайд хамрагдсан байгаа тул газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор улсын нөөцөд авсан талбайг хэсэгчлэн гаргуулах талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яамд хүсэлт явуулсан боловч зөвшөөрөгдөөгүй байна.

Цаашид улс, орон нутгийн нөөцөд хамрагдахгүй газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөцийг тогтоох ажлыг зохион байгуулж, олборлолтын зөвшөөрөл олгосноор энэ зөрчигдөж байгаа асуудал шийдэгдэхээр байгааг анхаарч үзэх нь зүйтэй юм.

1.4 Орон нутаг дахь бичил уурхайн ашигт малтмал олборлолт үр дүнтэй эсэх**1.4 Аймгийн хэмжээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гарсан 1 нэгж талбай байна.**

Аймгийн хэмжээнд 2021 оны байдлаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гарсан 5.71 га 1 нэгж талбай байна. ЗГ-ын 2017 оны 151 дүгээр тогтоолын хавсралт “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох” журмын дагуу 2018 онд Алтай сумын “Замын ам” талбайд нөхөрлөлүүд сумын Засаг даргатай гэрээ байгуулан бичил уурхайгаар ашигт малтмал олборложээ. Гэвч зарим бичил уурхай эзэмшигчтэй гэрээ байгуулаагүй, зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлуулсан, бичил уурхай эзэмшигчдээр нөхөн сэргээлт хийсэн эсэх нь тодорхойгүй, нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн аваагүй зөрчил аудитаар илэрсэн. Тус газарт 2019-2021 онуудад гэрээ байгуулаагүй байна.

1.7. БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ДҮГНЭЛТ ГАРСАН ТАЛБАЙ, аймгаар 2021.ИИ.31

	Дүгнэлт гарсан талбай		Хэмжээ	
	Тоо	Хувь	Га	Хувь
БҮГД	262	100%	1063.7	100%
Архангай	1	0.4%	4.75	0.4%
Баян-Өлгий	2	0.8%	53.74	5.1%
Баянхонгор	57	21.8%	152.25	14.3%
Булган	29	11.1%	126.36	11.9%
Говь-Алтай	1	0.4%	5.71	0.5%
Дархан-Уул	6	2.3%	16.56	1.6%
Дорноговь	2	0.8%	9.57	0.9%
Дорнод	2	0.8%	26.25	2.5%
Дундговь	13	5.0%	104.52	9.8%
Өвөрхангай	20	7.6%	39.71	3.7%
Өмнөговь	20	7.6%	86.29	8.1%
Сэлэнгэ	52	19.8%	220.05	20.7%
Төв	12	4.6%	78.31	7.4%
Улаанбаатар	5	1.9%	18.96	1.8%
Ховд	4	1.5%	11.25	1.1%
Хэнтий	36	13.7%	109.42	10.3%

Эх сурвалж: Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс, АМГТГ

⁵ Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө



Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Зарим газар нутгийг бичил уурхайн зориулалтаар аймгийн тусгай хэрэгцээнд авах тухай” 15 дугаар тогтоолоор Есөнбулаг сумын Рашаант багийн “Зүрх толгойн ар салаа”-4.97 га, “Шавагт салаа”-0.28 га бүхий 2 газрыг бичил уурхайн зориулалтаар 5 жилийн хугацаатайгаар аймгийн тусгай хэрэгцээнд авах саналыг Ашигт малтмалын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.

2021 оны шинэчилсэн бүртгэлээр аймгийн хэмжээнд 1 холбоо 35 нөхөрлөлийн 360 бичил уурхайчид бүртгэлтэй. Бичил уурхайн эрхзүйн орчин, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагаа, нөхөн сэргээлтийн аргачлал, цаашид хамтран ажиллах чиглэлээр уулзалт, зөвлөгөөн, туршлага судлах аяллыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажиллаж байна. Тус холбоо нь 2012 оноос хойш хууль бус үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон 70.1 га талбайд бичил уурхайн журам болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр нөхөн сэргээлтийн ажлыг хийж Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүлээлгэн өгч ажиллажээ.



Хүснэгт-2 Бичил уурхайчдын нөхөн сэргээсэн газрын мэдээлэл

Нөхөн сэргээсэн газрын хэмжээ	2013 он	2014 он	2015 он	2017 он	2018 он
	7 га	32.9 га	12.1	11 га	8 га

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын газраас

Эвдэрсэн газрын тооллогыг 2017 онд зохион байгуулснаар 15 сумын 159 газрын 415.26 га газар эвдрэлд орж орхигдсон судалгаа гарсан байна. Үүнээс гар аргаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон 14 сумын 371.26 га талбай тоологдсоноос хамгийн их талбай эвдрэлд орсон нь Есөнбулаг, Тонхил, Шарга, Чандмань, Тайшир, Бигэр сумд байжээ.

Эвдэрсэн газрын тооллого судалгааны үр дүнд үндэслэн 71 газрыг бичил уурхайгаар ашиглах боломжтой эсэх талаар Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст хүргүүлсэн байна. Үүнээс 16 газрын 80.26 га талбайг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авч бүртгүүлснээр ашиглах боломжтой гэж үзжээ. Үүнд:

- ✓ Алтай сумын Баянцагаан багийн “Шувуутын сайр”-3.36 га
- ✓ Есөнбулаг сумын Рашаант багийн “Майханы хуруу”-18.85 га, “Билүүтийн эх”-0.9 га, “Билүүт”-3.49 га, “Малзан”-2.57 га, “Шавагт салаа”-0.8 га, “Нарийн хөтөл”-5.36 га, “Өндөр дэнж”-2.33 га, Наран багийн “Их худаа”-1.8 га
- ✓ Чандмань сумын Өлзий булаг багийн “Хөх сайр”-36.97 га
- ✓ Цогт сумын Баян-Улаан багийн “Цагаан толгойн огтрог”-3.7 га
- ✓ Шарга сумын Сондуулт багийн “Наран шувуу толгойн өвөр”-0.05 га, “Нарангийн Засвар булаг”-0.03 га

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 4.3⁶-т заасны дагуу 2021 оны 04 сард Бигэр сумын Засаг дарга, “Марко Поло” ХХК-ийн захирал, “Алтайн бичил уурхайн эв нэгдлийн холбоо” гурвалсан гэрээ байгуулж бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоор гэрээ байгуулаад байна.

Хяналт:

Зураг 1. Хууль бус ашигт малтмалын олборлолтод хийсэн хяналт

Хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэд, нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг таслан зогсоох хөөх, хууль журмын хүрээнд ажиллах эрхзүйн зөвлөгөө өгөх арга хэмжээг авч ажиллаж байна. Есөнбулаг, Бугат, Тайшир, Алтай, Чандмань, Шарга сумдын нутагт хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдэд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрх зүйн орчны чиглэлээр мэдээлэл хийж холбогдох гарын авлага, материал тараан ажиллажээ.



⁶ Сум, дүүргийн Засаг дарга, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасны дагуу гурвалсан гэрээ байгуулсны үндсэн дээр бичил уурхайгаар ашигт малтмал олборлоно.



БҮЛЭГ 2: Уул уурхайн нөхөн сэргээлтийн хэрэгжилт үр дүнтэй эсэх

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛУУЛДАГГҮЙ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН ИРҮҮЛДЭГГҮЙ, БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ДАНСАНД БАЙРШУУЛСАН МӨНГИЙГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИД БУЦААН ОЛГООГҮЙ ЗӨРЧИЛ БАЙСААР БАЙНА.

2.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн эсэх

2.1 Уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэн дүгнэлт өгчээ.

Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1⁷-т заасны дагуу сонгон шалгаруулалтын журмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд уг зөвшөөрөл авсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулахаар байна.

Аймгийн хэмжээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дагуу төмрийн хүдрийн-1, алтны шороон ордын-3, нүүрсний-2 нийт 6 уурхай үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх уурхайчдын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг 4 удаагийн явцын хяналт шалгалтыг зохион байгуулж, заавар зөвлөмжийг өгч ажилласнаас гадна уул уурхайн олборлолтод өртсөн 9.36 га талбай, түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтод өртсөн 52.77 га талбайд хийсэн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь хэмжилт хийн шалгаж, акт үйлдэн хүлээн авсан байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны А/05 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах" журамд зааснаар 2014-2018 оныг дуустал БОМТ-

ний хэрэгжилтийг 80 онооноос дээш дүгнэгдсэн тохиолдолд дараа жилийн төлөвлөгөөг батлах эрх зүйн зохицуулалттай байсан бол 2019 оны А/618 дугаар тушаалаар журмыг шинэчлэгдэж 90 онооноос дээш авсан тохиолдолд дараа оны төлөвлөгөөг батлахаар зохицуулалтыг хийсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах тайлагнах журам"-ын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын баг "Гоби коулд энд энерги ХХК"-ийн Зээгтийн нүүрсний уурхай, "Болдгянтболд" ХХК-ийн Зүүн сайрын алтны шороон ордын уурхай болон "Майн бласт" ХХК-ийн тэсрэх материалын агуулах, цогцолборын 2020 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэн хангалттай гэсэн дүгнэлтийг өгчээ.

Харин "Алтайн хүдэр" ХХК-ийн Таяннуурын төмрийн хүдэр, гантигжсан шохойн чулууны ордын уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж шалган хангалтгүй дүгнэлтийг өгч, тайлангийн иж бүрдэл дутуу "Цогц эрин транс" ХХК-ийн Бөөрөгийн алтны шороон ордын уурхайн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх ажил хүлээгдсэн байна.

⁷ энэ хуулийн 24.1-д заасан этгээд ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө, сонгон шалгаруулалтын журмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд уг зөвшөөрөл авсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах;



Хүснэгт-3

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Д/д	Сум нэр	Уурхайн нэр	Ашигт малтмалын төрөл	Эзэмшигчийн нэр	Үйл ажиллагаа явуулж эхэлсэн он	Талбайн хэмжээ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэсэн дүгнэлт оноо		
							2018 он	2019 он	2020 он
1	Тонхил, Бугат	Бөөрөг	Алт	Цогц эрин транс ХХК	2,017	22.5728	81.89	90.9	Дүгнэгдээгүй
2	Чандмань	Зээгт	Нүүрс	Гоби коулд энд энержи ХХК	1,980	20.3067	75.3	91.35	91.09
3	Дэлгэр	Хөв булаг	Нүүрс	Мандал-Алтай групп ХХК	2,015	6.32206	89.19	Төлөвлөгөөгүй ажилласан	Төлөвлөгөөгүй ажилласан
4	Цэрл	Таяннуур	Төмрийн хүдэр, гантигжсан шохойн чулуу	Алтайн хүдэр ХХК	2,008	81.3601	81.09	90.43	63.1
5	Есөнбулаг сум	Зүүн сайр	Алт	Болдгянтболд ХХК	2,019	1.15021	0	90.45	90
6	Бигэр	Булаг, Хуурай	Алт	Эн Си Жи и Ти ХХК	2,017	0.00000	81	Дүгнэгдээгүй	Ажиллаагүй

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулахаар бэлтгэл ажил хангаж буй “Хан-Алтай ресурс” ХХК-ийн 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө танилцуулах уулзалтыг холбогдох төрийн байгууллагын төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулж санал өгч ажиллажээ.

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулахаар “Болд гянт болд” ХХК-ний Зүүн сайрын уурхай, “Хан-Алтай ресурс” ХХК-ний Хан алтайн алтны уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөө Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас батлагдаж ирсэн. Мөн Бигэр, Есөнбулаг, Эрдэнэ сумд хайгуулын үйл ажиллагаа явуулахаар Марко поло, Апполо капитал, Металл эрэл хайгуул, Эн Си Жи Ти, Дадоро, Зөөлөн ресурс гэсэн 6 аж ахуйн нэгж байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянуулж бүртгүүлээд байна.

2.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн эсэх.

2.2 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2018-2020 онд давхардсан тоогоор 306 лиценз эзэмшигч менежментийн төлөвлөгөө батлуулаагүй, 87 лиценз эзэмшигч нөхөн сэргээлтийн тайлан ирүүлж дүгнүүлээгүй байна.

Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ:

2018-2020 онуудад нийт 230,445.4 га-д газар хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Бэлчээр ба бусад өвслөг ургамал бүхий газрын 228250 га-д, хот тосгон бусад суурины газрын 86.8 га-д, ойн сан бүхий газар 2054.2 га, усны сан бүхий газар 5.5 га-д, уурхайн эдэлбэр газрын 48.92 га талбайд тус тус хамгаалалтын арга хэмжээ авсан байна.



Уул уурхайн байгаль хамгаалах нөхөн сэргээлт

Аймгийн нийт нутаг дэвсгэрт ашигт малтмалын 139 тусгай зөвшөөрөл олгогдсон бөгөөд 4.2 хувийг эзэлж байна. 2018-2020 онуудад хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 25-аар буюу 237.4 мянган га-аар буурсан бол ашиглалтын тусгай зөвшөөрөл 5-аар буюу 3.1 мянган га-аар нэмэгдсэн байна.






2020 оны байдлаар 15 сумд хайгуулын 84, 12 сумд ашиглалтын 55, 4 сумд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 6 зөвшөөрөл олгогдсон байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 55 талбай бүртгэлтэй байгаагаас 2017 онд “Алтайн хүдэр” ХХК-ний Таяннуурын төмрийн хүдэр, Гоби коулд энд энерги ХХК-ий Зээгт, “Мандал алтай групп”

ХХК-ний Хөв булгийн хүрэн нүүрсний нийт 3 уурхай үйл ажиллагаагаа явуулж байсан бол 2018-2020 онуудад “Эн Си Жи Ти” ХХК-ний Хуурайн, “Болдгянтболд” ХХК-ний Зүүн сайр, “Цогц эрин транс” ХХК-ний Бөөрөгийн алтны шороон ордын уурхайд нэмэгдэн үйл ажиллагаагаа явуулж тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Дээрх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж 2017-2020 онуудад 34.43 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэжээ.


Хүснэгт-4

Нөхөн сэргээлт

Дд	Уурхайн нэр	Сумын нэр	Үйл ажиллагаа явуулсан он	Уулын ажилд хамрагдсан талбай /га/	Нөхөн сэргээлт хийсэн талбай /га/	
					техникийн	биологийн
1	Хуурай	Бигэр	2017-2019	7.4	2.5	0
2	Бөөрөг	Тонхил, Бугат	2017	4.8	0	0
			2018	19.02	5.28	0
			2019	6.86	4.08	0
			2020	2.65	22.57	0
3	Зээгт	Чандмань	1975	20.3	0	0
4	Хөв булаг	Дэлгэр	2015	6.3	0	0
5	Таяннуур	Цээл	2008	81.3	0	0
6	Зүүн сайр	Есөнбулаг	2019	5.0	0	0
7	Мааньт	Төгрөг	1979	7.4	0	0
Нийт				161.03	34.43	0

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын газраас

Мөн Таяннуурын уурхайгаас Бургастай боомт хүртэл тавигдаж буй 168.3 км замын ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтыг үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 52.77 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийлгэн хүлээн авсан.



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд аж ахуйн нэгж байгууллага хуульд заасан эрх үүргийнхээ дагуу үйл ажиллагаа явуулж тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлуулж, нөхөн сэргээлтийн баталгаа тусгай дансанд хөрөнгийг жил бүр байршуулан журмын дагуу буцаан авч тайлангаа тайлагнан, дүгнүүлэн ажиллахаар байна.



Хүснэгт-5 Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн судалгаа

Лиценз эзэмшигчийн төрөл	Огноо	Хайгуул хийсэн					хайгуул хийгээгүй			Менежментийн төлөвлөгөө		Нөхөн сэргээлт хийгдсэн эсэх	
		лиценз эзэмшигч төлөвлөгөө хануулсан эсэх	Хайгуулын тайлан ирүүлсэн эсэх	үүнээс БОМТ батлуулсан	үүнээс БОМТ батлуулаагүй	лиценз эзэмшигч	үүнээс БОМТ батлуулсан	үүнээс БОМТ батлуулаагүй	батлуулсан лиценз эзэмшигчийн тоо	батлуулсаагүй лиценз эзэмшигчийн тоо	төлөвлөгөөний биелэлтийг баталгаажуулж ирүүлсэн	тайлан ирүүлээгүй	
Хайгуулын	2018 он	23	7	6	20	3	132	40	92	60	95	25	35
	2019 он	31	13	9	31	-	107	25	80	56	80	24	32
	2020 он	30	15	13	28	1	82	20	62	48	63	28	20
	2021 он	5	1	1	4	1	76	9	67	13	68	-	-
Нийт дүн		89	36	29	83	5	397	94	301	177	306	77	87

Эх сурвалж: Сумдын байгаль орчны улсын байцаагч, аудитын судалгаа

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллага нь 2018-2021 онуудад давхардсан тоогоор 397 нэгж талбарт хайгуул хийгээгүй, 306 лиценз эзэмшигч менежментийн төлөвлөгөө батлуулаагүй, менежментийн төлөвлөгөө батлуулснаас 87 лиценз эзэмшигч нь нөхөн сэргээлтийн тайлан ирүүлж дүгнүүлээгүй байна.

2.3 Нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг холбогдох журмын дагуу байршуулж зарцуулсан эсэх.

2.3 Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэлд тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан лиценз эзэмшигчийн 109,103.6 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгө:

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 2.3.2⁸, Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8⁹-т заасны дагуу ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулж буй сум, дүүргийн Засаг даргаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг байршуулахаар заасан.

Хүснэгт-6 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ /мянган.төгрөг/

Лиценз эзэмшигчийн төрөл	Огноо	БОНХС-ийн менежментийн төлөвлөгөө батлуулсан			Нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгө байршуулсан		Дутуу төвлөрүүлсэн		Илүү төвлөрүүлсэн		Нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө батлуулаагүй боловч мөнгөн		Буцаан олговол зохих нөхөн сэргээлтийн		Буцаан олгосон		Буцааж олгоогүй барьцаа хөрөнгийн үлдэгдэл	
		Лиценз эзэмшигчийн тоо	нөхөн сэргээлтэд шаардлагатай мөнгөн хөрөнгө	Байршуулах ёстой мөнгөн хөрөнгө	Лиценз эзэмшигчийн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө	Лиценз эзэмшигчийн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө	Лиценз эзэмшигчийн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө	Лиценз эзэмшигчийн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө	Лиценз эзэмшигчийн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө	Лиценз эзэмшигчийн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө	Лиценз эзэмшигчийн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө
Хайгуулын	2018 он	60	39,233.2	19,616.6	49	17,809.5	12	2,607.1	7	800.0	28	10,950.0	77	28,759.5	19	10,100.0	58	18,909.5
	2019 он	56	40,182.8	20,091.4	43	18,800.0	11	3,616.4	9	2,325.0	18	8,950.0	61	27,750.0	13	10,329.5	48	17,420.5
	2020 он	48	44,200.0	22,850.0	43	23,400.0	5	1,100.0	6	1,650.0	6	1,925.0	49	25,325.0	4	2,200.0	45	23,125.0
	2021 он	13	8,115.0	4,057.5	2	1,000.0	10	3,057.5	-	-	7	3,685.0	9	4,685.0	-	-	9	4,685.0
Нийт дүн		177	131,731.0	66,615.5	137	61,009.5	38	10,381.0	22	4,775.0	59	25,510.0	196	86,519.5	36	22,629.5	160	64,140.0

Эх сурвалж: Сумдын байгаль орчны улсын байцаагч, аудитын судалгаа

2018-2021 онуудад 177 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд 131,731.0 мянган төгрөгийг зарцуулахаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулжээ. Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн зардлын 50 хувь болох 66,615.5 мянган төгрөгийг сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэхээр байна. Үүнд:

⁸ ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулж буй сум, дүүргийн Засаг даргаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг “Ашигт малтмалын тухай” хуулийн 38.1.8-д заасан хувь хэмжээгээр

⁹ байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх



- ✓ Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд 61,009.5 мянган төгрөгийг байршуулснаар төвлөрүүлбэл зохих дүнгээс 10,381.0 мянган төгрөгийг дутуу, 4,775.0 мянган төгрөгийг илүү байршуулжээ.
- ✓ Нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө батлуулаагүй боловч 25,510.0 мянган төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн дансанд байршуулсан.
- ✓ Нийт буцаан олговол зохих 86,519.5 мянган төгрөгийн барьцаа хөрөнгөнөөс 22,629.5 мянган төгрөгийг буцаан олгон 64,140.0 мянган төгрөгийг олгоогүй байна. Үүнээс нөхөн сэргээлтийн мэдээ гаргаагүй, тайлан ирүүлээгүй 87 лиценз эзэмшигчийн 23,430.0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө байна.
- ✓ Сумын Засаг дарга байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлахдаа баталгааны мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх хугацааг тогтоож өгөөгүйгээс болж дутуу байршуулсан мөнгөн хөрөнгөнд журмын дагуу алданги тооцоогүй байна.

Сумдын байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансны талаар:

Сумдын байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд 2018-2021 оны хооронд дараах орлого зарлагын гүйлгээ хийгджээ. Үүнд:

- ✓ Сумдын Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд 2018 оны эхэнд 146,661.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.
- ✓ Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа болгож 86,519.5 мянган төгрөгийг байршуулсан.
- ✓ Алтай сумын бичил уурхай эрхлэгч нөхөрлөлүүдээс нөхөн сэргээлтийн барьцаанд 35,700.0 мянган төгрөгийг байршуулжээ.
- ✓ Тонхил сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд 1100.0 мянган төгрөгийн орлогыг дансаар дамжуулан гаргасан.
- ✓ Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн 47,865.7 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид буцаан олгосон.
- ✓ Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр 650.0 мянган төгрөгийг зарцуулсан.
- ✓ Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байршуулсан хөрөнгөнөөс нийт 34,238.8 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулжээ.
- ✓ Сумдын Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 187,226.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.


Барьцаа хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан талаар:

Алтай сум нь 2018 онд бичил уурхайгаар сумын Засаг даргатай гэрээ байгуулан ашигт малтмал олборлуулсан ба 2018 онд 20 нөхөрлөл, хоршооноос 31,700.0 мянган төгрөг, 2019 онд 2 нөхөрлөлөөс 4,000.0 мянган төгрөг, нийт 35,700.0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө төвлөрсөн байна.

Бичил уурхай эрхлэгчидтэй холбоотой баримт материал ирүүлээгүйн улмаас төвлөрүүлэх мөнгөн дүнг бүрэн төвлөрүүлсэн эсэх, талбайд нөхөн сэргээлт хийлгэж хүлээн авсан эсэх, хэдий хугацаанд олборлолт явуулсан эсэх нь нотлох баримтаар дэмжигдэхгүй байна.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний 3.1.12¹⁰-т заасны дагуу нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулахаар заасан боловч бичил уурхай эрхлэгчдээс нөхөн сэргээлтийн санд төвлөрүүлсэн барьцаа хөрөнгөнөөс 2018-2021 онд зориулалт бусаар 34,238.8 мянган төгрөг зарцуулжээ. Үүнд:

- ✓ Зэл өвсний устгал хийхэд 1,100.0 мянган төгрөг, шатахуунд 8,921.3 мянган төгрөг, хайс хийхэд 5,382.0 мянган төгрөг, чуулганы зардалд 345.0 мянган төгрөг, модны суулгацын үнэ 983.0 мянган төгрөг, мотоцикл авахад 1,950.0 мянган төгрөг, нохой устгалд 607.5 мянган төгрөг, булгийн эх хаших, хөв байгуулахад 11,000.0 мянган төгрөг, худаг гаргахад 300.0 мянган төгрөг, бусад зардалд 3,650.0 мянган төгрөг, нийт 34,238.8 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.



¹⁰ Нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах



Үүнээс Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар зориулалт бусаар зарцуулсан 2,677.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 8,770.0 мянган төгрөгийн зөрчилд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн гэх албан бичиг ирүүлсэн боловч зөрчлийг жил бүр давтан гаргасан байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн талаар:

Хүснэгт-7 Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансны бүртгэл /мян.төг/

дд	Байгууллага	Дансны дугаар	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /2021.05.04/	Тайланд өглөг тусгасан дүн 2021.05	Тайланд авлага тайлагнасан дүн 2020.12.31	Зөрүү	Хугацаа дууссан лиценз эзэмшигчийн төлбөр	Байршуулсан мөнгийг үлдээх санал
1	Алтай БХНС	100050255402	39,748.5	25,335.0	1,915.5	16,329.0	6,360.0	4,000.0
2	Баян-Уул БХНС	100050355402	751.6	-	-	751.6	751.6	-
3	Бигэр БХНС	100050355402	7,703.0	7,703.0	-	-	3,883.0	-
4	Бугат БХНС	100050455402	6,497.4	6,300.0	-	197.4	2,550.0	-
5	Дарив БХНС	100050555402	1,017.5	600.0	-	417.5	1,017.5	-
6	Дэлгэр БХНС	100050655402	11,070.6	6,050.0	-	5,020.6	4,120.6	-
7	Жаргалан БХНС	100050755402	-	-	-	-	-	-
8	Тайшир БХНС	100050855402	22,857.2	22,857.2	-	-	14,557.2	-
9	Тонхил БХНС	100050955402	34,196.4	-	-	34,196.4	31,346.4	-
10	Төгрөг БХНС	100051055402	22,596.3	11,665.0	-	10,931.3	24,207.1	-
11	Халиун БХНС	100051155402	1,201.9	1,201.9	-	-	101.9	-
12	Хөхморьт БХНС	100051255402	1,750.0	1,750.0	-	-	350.0	-
13	Цогт БХНС	100051355402	2,163.8	2,163.8	-	-	3,169.0	-
14	Цэрл БХНС	100051455402	7,582.7	7,582.7	-	-	2,185.0	-
15	Чандмань БХНС	100051555402	-	-	-	-	-	-
16	Шарга БХНС	100051655402	3,000.0	1,000.0	-	2,000.0	1,750.0	950.0
17	Эрдэнэ БХНС	100051755402	18,312.5	16,212.5	-	2,100.0	11,652.5	-
18	Есөнбулаг БХНС	100050155402	6,776.8	6,776.8	-	-	1,101.8	-
Нийт дүн			187,226.2	117,197.9	1,915.5	71,943.8	109,103.6	4,950.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 187,226.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа боловч санхүүгийн тайланд тусгасан өглөгийг 117,197.9 мянган төгрөг, авлагыг 1,915.5 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Аудитаар Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн мөнгөн хөрөнгө, өглөгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байршуулсан мөнгөн дүнгээр салган харуулах гэсэн боловч санхүүгийн тайланд өглөгийг бөөн дүнгээр илэрхийлсэн, хэнд хэдэн төгрөгийн өглөгтэй нь тодорхойгүй байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг түүнд буцааж өгөх ёстой. Гэтэл жил бүр менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж байршуулсан мөнгөн хөрөнгийг буцааж өгөөгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь нэхэмжлээгүй байсаар жил бүр өглөгийг нэмэгдүүлсэн байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс байршуулсан мөнгөн хөрөнгөнөөс дансанд нь үлдээх 4,950.0 мянган төгрөгийн санал ирүүлжээ.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байршуулсан мөнгөөр тооцож үзэхэд 187,226.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс хугацаа дууссан лиценз эзэмшигчийн байршуулсан 109,103.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй тооцоо нийлж өглөгийг барагдуулах, нөгөө талаас тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан лиценз эзэмшигчийн байршуулсан мөнгөн хөрөнгийг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх хэрэгтэй юм.



БҮЛЭГ 3: Орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн эсэх

УУЛ УУРХАЙН САЛБАРТ ЗӨРЧИГДӨЖ БАЙГАА АСУУДЛЫГ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ШИЙДВЭРЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХААР БАЙНА.

3.1 Орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа эсэх

3.1 Орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байна.

Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь “Мандал Алтай групп” ХХК-ний Хөв булгийн уурхай, “Эн Си Жи Ти” ХХК “Хуурай” нэртэй талбай, “Алтайн хүдэр” ХХК-ийн Таяннуурын уурхай, “Марко поло” ХХК, Болд гянт болд ХХК, “Мандал-Алтай групп” ХХК-ийн Хөв булгийн уурхайн үйл ажиллагаа, байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалган зөвлөмж өгч ажилласан байна.

“Нөхөн сэргээлт-2020” арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлын талаар:

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Нөхөн сэргээлт-2020” арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020 оны А/149 тоот захирамжаар Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар, Байгаль орчин аялал, жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газар, Тагнуулын хэлтэс, сумдын ЗДТГ зэрэг төрийн байгууллагууд хамтран хэрэгжүүлжээ. Үүнд:

- ✓ Аймгийн хэмжээнд уул уурхайн болон хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газруудын судалгааг шинэчлэн гаргаж, хариуцах эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийхэд шаардагдах төсвийг тооцоолон хөрөнгийн эх үүсвэрийг хайх
- ✓ Аймгийн хэмжээнд хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг зөрчил илэрсэн тохиолдолд таслан зогсоох арга хэмжээг авч ажиллах.
- ✓ Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шалгалт хийн зөвлөн туслах арга хэмжээг авч, нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэх
- ✓ Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр ухуулга, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, телевиз, олон нийтийн сүлжээгээр иргэд олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шалгалт хийн зөвлөн туслах арга хэмжээг авч, нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэх арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- ✓ Тайлант хугацаанд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 4, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3, тэсэлгээний материалыг үйлдвэрлэх, хадгалах тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шалгалт хийн зөвлөн туслах арга хэмжээг авч, нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэх зорилгоор дараах ажлуудыг хийлгэж, тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт тавьсан.
- ✓ Ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа 2 уурхайн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийн арилгуулан зорилгоор 31 заалт бүхий 2 албан шаардлага хүргүүлж, 11.0 сая төгрөгийн торгууль ноогдуулан ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийсэн.
- ✓ Есөнбулаг, Бигэр, Чандмань, Эрдэнэ, Цээл, Алтай, Бугат, Тонхил, Шарга сумдын нутаг дэвсгэрт хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 8 аж ахуйн нэгжүүдийн 2020 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт шалгалт хийн зөвлөн туслах арга хэмжээг авч, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэн акт үйлдэн хүлээн авах ажлыг зохион байгуулсан.
- ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө орчны хяналт шинжилгээ хийлгэсэн дүн мэдээнд мониторинг хийж харьцуулан, үүсээд байгаа гол нөлөөллийг зөв тодорхойлж чаддаггүйгээс менежментийн төлөвлөгөөг оновчгүй төлөвлөгдөн, хэрэгжилтийг хангаж ажиллахад санхүүгийн хүндрэл бэрхшээл үүсэж байна гэсэн дүгнэлт хийж, 8 аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч зөвлөмж хүргүүлжээ.



- ✓ Тухайн жилийн хайгуулын болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд 3 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 0.82 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийн орон нутагт хүлээлгэн өгсөн байна
- ✓ Цээл сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Таяннуурын уурхайгаас Бургастай боомт хүртэлх 168.3 км замын ажлыг тус аймгийн 4 сумын нутаг дэвсгэрийг дамнуулан гүйцэтгэхдээ түгээмэл тархацтай ашигт малтмалын нийт 32 карьер нээснээс, Цээл сумын нутагт хамрах 12 карьерийн 52.8 га талбайд нийт 12,989.5 мянган төгрөгийг зарцуулан техникийн нөхөн сэргээлт хийснийг хянаж шалгаж, хэмжилт хийн хүлээн авч акт үйлдсэн.
- ✓ Тонхил, Бугат сумын нутагт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Бөөрөгийн алтны шороон ордын уурхайн 2018-2019 онуудад нийт 9.4 га талбайн техникийн нөхөн сэргээлтийг 27,930.9 мянган төгрөгөөр зарцуулан хийсэн бөгөөд тус ажлыг стандартын шаардлага хангуулан хүлээн авч акт үйлдэн ажиллажээ.

Хүснэгт-8 Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын судалгаа

Д/д	Сум нэр	Уурхайн нэр	Талбайн хэмжээ	Солбилцол		Эзэлхүүн	Эвдрэлд орсон он	Эзэмшигчийн нэр
1	Төгрөг	Мааньтын уурхайн ухаш	7.46107	94° 43' 5.854"	45° 47' 18.660"	2238300	2003	Мандал алтай групп ХХК
2	Тонхил, Бугат	Бөөрөг	22.5728	94° 10' 28.710"	45° 50' 40.235"	675000	2019-2020	Цогц эрин транс ХХК
3	Чандмань	Зээгтийн уурхайн овоолго	11.7926	97° 53' 37.349"	45° 22' 29.213"	1145903.1	1979-2020	Гоби коулд энд энерги ХХК
4	Чандмань	Зээгтийн уурхайн карьер	20.3067	97° 53' 20.778"	45° 22' 12.616"	1782844.5	1979-2020	Гоби коулд энд энерги ХХК
5	Төгрөг	Мааньтын уурхайг овоолго	2.56616	94° 43' 10.101"	45° 47' 27.247"	516600	1979	Мандал-Алтай групп ХХК
6	Дэлгэр	Хөв булгийн уурхайн карьер	6.32206	97° 17' 49.985"	46° 12' 11.483"	1896000	2014	Мандал-Алтай групп ХХК
7	Дэлгэр	Хөв булгийн уурхайн овоолго	9.18677	97° 17' 59.791"	46° 12' 19.879"	918000	2014	Мандал-Алтай групп ХХК
8	Цээл	Таяннуур хаягдлын овоолго-1	13.2221	95° 38' 40.611"	45° 32' 4.776"	3433009	2014	Алтайн хүдэр ХХК
9	Цээл	Таяннуур хаягдлын овоолго-2	19.5785	95° 38' 16.620"	45° 32' 12.954"	4875660	2012	Алтайн хүдэр ХХК
10	Цээл	Таяннуур хаягдлын овоолго-3	9.85236	95° 38' 40.017"	45° 31' 55.205"	1802738	2011	Алтайн хүдэр ХХК
11	Цээл	Таяннуур хөрсний овоолго-1	21.8293	95° 39' 8.780"	45° 33' 13.597"	8185015	2009	Алтайн хүдэр ХХК
12	Цээл	Таяннуур хөрсний овоолго-2	21.575	95° 39' 17.211"	45° 32' 59.405"	14338004	2009	Алтайн хүдэр ХХК
13	Цээл	Таяннуур хөрсний овоолго-3	35.2418	95° 39' 2.489"	45° 32' 29.684"	7832000	2015	Алтайн хүдэр ХХК
14	Цээл	Таяннуур карьер	81.3601	95° 38' 32.331"	45° 33' 4.685"	47641454	2009	Алтайн хүдэр ХХК
15	Есөнбулаг сум	Зүүн сайр уурхайн карьер	1.15021	96° 44' 31.544"	46° 3' 56.762"	80500	2020	Гянт болдгянт ХХК
16	Есөнбулаг сум	Зүүн сайр уурхайн тунгаах нуур	0.463055	96° 44' 57.088"	46° 3' 41.092"	32200	2020	Гянт болдгянт ХХК
17	Есөнбулаг сум	Зүүн сайр уурхайн цэвэр нуур	0.475828	96° 44' 58.603"	46° 3' 38.736"	32900	2020	Гянт болдгянт ХХК
18	Есөнбулаг сум	Зүүн сайр уурхайн карьер	3.9997	96° 44' 48.307"	46° 3' 47.288"	279300	2020	Гянт болдгянт ХХК
НИЙТ ДҮН			288.95611					

Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн 6 сумын 18 нэгж талбарт 288.9 га газар байна. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Нөхөн сэргээлт 2024” арга хэмжээний хүрээнд ажлын хэсэг байгуулагдан төлөвлөгөө гарган 2021 онд уул уурхайн олборлолтод өртсөн 22.5 га, дэд бүтцийн 18 га, хууль бусаар ашигт малтмал олборлолтод өртсөн 7.9 га нийт 47 орчим га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэх зорилт тавьжээ.

3.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь Ашигт малтмалын хуульд заасан үүргээ биелүүлж байгаа эсэх

3.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь хуулийн дагуу үүргээ биелүүлж ажиллахгүй байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагууд нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс уурхайг хүлээн авсны дараа уг уурхайг ашиглуулж эхлүүлдэг. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилээр олгодог бөгөөд ашиглалт явуулахгүй байгаа тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах эсэх талаар одоогоор Монгол улсын ямар нэгэн хууль тогтоомжид заагаагүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.1¹¹-т заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 30 хоногийн, дараагийн жилүүдэд тухайн оны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 15-ны дотор төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын албанд

¹¹ Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь мэдээ, тайлан, төлөвлөгөөг дор дурдсан хугацаанд үнэн зөв гаргаж төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын албанд хүргүүлнэ. 48.1.1.хайгуулын ажлын төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 30 хоногийн, дараагийн жилүүдэд тухайн оны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 15-ны дотор;



хүргүүлэх, 33 дугаар зүйлийн 33.1¹²-т заасны дагуу хайгуулын ажлыг жил бүр хийж гүйцэтгэхээр байна.

Хүснэгт-9 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үүргийн биелэлт

Лиценз эзэмшигчийн төрөл	Огноо	Хайгуул хийгээгүй лиценз эзэмшигч	Менежментийн төлөвлөгөө батлуулаагүй лиценз	Нөхөн сэргээлтийн тайлан ирүүлээгүй
Хайгуулын	2018 он	132	95	35
	2019 он	107	80	32
	2020 он	82	63	20
	2021 он	76	68	-
Нийт дүн		397	306	87

Лиценз эзэмшигчийн төрөл	Огноо	Лиценз эзэмшигчийн тоо	Ү/а огт эхлээгүй байгаа
Ашиглалт	2018 он	55	48
	2019 он	55	47
	2020 он	55	47
	2021 он	55	46
Нийт дүн		188	

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 55 лиценз эзэмшигч байгаагаас 2018-2021 оны хооронд 46-48 тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаа явуулаагүй байна.

Мөн тус онуудад давхардсан тоогоор хайгуул хийгээгүй 397, менежментийн төлөвлөгөө батлуулаагүй 306, нөхөн сэргээлтийн тайлан ирүүлээгүй 87 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.

Эх сурвалж: Аудитын судалгаа

3.3 Хууль бус ашигт малтмал олборлолт, тэдгээрийг таслан зогсоосон эсэх.

3.3 Аймгийн хэмжээнд хууль бус олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 9 сумын 50 нэгж талбарт 159.4 га газар байна.

Аймгийн хэмжээнд уул уурхайн болон хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газруудын тооллого судалгааны ажлын хүрээнд:

- ✓ Хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон эзэн холбогдогч нь тодорхойгүй нөхөн сэргээлт хийх шаардлагатай газар 2017 онд 304.47 га тоологдсон бол 2020 оны байдлаар 167.74 га талбай тоологдож 139.73 га талбай хасагдсан үзүүлэлттэй байна. Энэ нь төсөл болон орон нутгийн төсвөөс 2017-2020 онд 25.49 га техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэсэн, 35.46 га талбай шинээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдсон талбайд орсон, үлдсэн 78.78 га талбай нь нөхөн сэргээлт хийх шаардлагагүй байгалийн аясаар нөхөн сэргээгдсэн байна.

Хүснэгт-10 Хууль бус олборлогчдын үйл ажиллагаанаас эвдрэлд орж орхигдсон газрын нөхөн сэргээлт

Нөхөн сэргээсэн газрын хэмжээ	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
	42.85 га	19.5 га	9.8 га	11 га	8 га	0	6.49

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын газраас

- ✓ 2020 онд сум, орон нутгийн төсөв болон төсөл хөтөлбөрүүдэд санал тавин эвдрэлд орж орхигдсон газруудад нөхөн сэргээлт хийх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэн ажиллах бодлогыг баримтлан санал хүргүүлэн ажилласан боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Хууль бусаар ашигт малтмал олборлох зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллажээ. Үүнд:

- ✓ “Нөхөн сэргээлт-2020” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус аймгийн нутаг дэвсгэрт хууль бусаар ашигт малтмал олборлож буй гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоох холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх ажлын хүрээнд Есөнбулаг сумын Хантайширын нурууны Өл, Ялаат, Шаврын гол, Шарга сумын Улаан туг багт Дааган сүүл, Тайшир сумын Далангийн нурууны Хөвийн ам нэртэй газруудад хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020 оны А/419 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу 3 удаа 95 иргэн, 37 тээврийн хэрэгслийг хөөн гаргаж 22 хайгч, 28 помп, моторыг түр хураан авч, бүртгэл үйлдэн хураан авч 1.58 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийлгүүлжээ.

Зураг 3.Хууль бус ашигт малтмал олборлох зөрчлийг арилгуулах арга хэмжээ

- ✓ Хууль бусаар ашигт малтмал ашиглах зорилгоор газрын хэвлийг дур мэдэн ашигласан 28 иргэнд “Зөрчлийн тухай” хуулийн дагуу зөрчлийн хэрэг нээн, 4.2 сая төгрөгийн торгуулийн арга



¹² Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон тухайн талбайн гектар тутамд дараахь хэмжээнээс багагүй зардал бүхий хайгуулын ажлыг жил бүр хийж гүйцэтгэнэ:



- хэмжээ авч, Цагдаагийн газарт нөхөн сэргээлт нэрийн дор хууль бусаар ашигт малтмал олборлож байсан 1 хэрэг шалгагдсан байна.
- ✓ Бигэр, Тайшир сумдын нутагт хууль бусаар олборлолт хийж байсан иргэдэд Шүүхийн шийдвэр гаргуулжээ.
 - ✓ Есөнбулаг, Чандмань сумдын нутагт хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон 2 газрын нийт 4.96 га талбайд 2 аж ахуйн нэгжийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлт хийлгэжээ.
 - ✓ Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр ухуулаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, телевиз, олон нийтийн сүлжээгээр иргэд олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулан ажиллажээ.

Хүснэгт-11 Хууль бус олборлогчдын үйл ажиллагаанаас эвдрэлд орж орхигдсон газар

Д/д	Эвдэрсэн газрын нэр	Байршил, газарзүйн координат					Эвдрэлд орсон цаг хугацаа (он)
		Сумын нэр	Талбайн хэмжээ (га)	Эвдэрсэн газрын эзэлхүүн (м3)	Уртраг	Өргөрөг	
1	Шувуутайн сайр салаа-3	Алтай	1.78	24920	94° 44' 2.481"	44° 59' 43.153"	2005
2	Шувуутайн сайр салаа-2	Алтай	0.08	1120	94° 43' 54.187"	44° 59' 31.018"	2005
3	Шувуутайн сайр салаа-1	Алтай	0.48	6720	94° 43' 49.744"	44° 59' 26.135"	2005
4	Дөрөлж - 1	Бигэр	6.33	316500	97° 5' 26.185"	45° 57' 24.252"	2005
5	Дөрөлж - 2а	Бигэр	1.96	39200	97° 5' 31.054"	45° 57' 9.244"	2009
6	Дөрөлж- 2b	Бигэр	0.22	4400	97° 5' 28.271"	45° 57' 20.100"	2009
7	Дөрөлж-3	Бигэр	2.25	40500	97° 5' 40.893"	45° 57' 13.156"	2009
8	Олонбулаг -1b	Бигэр	1.59	25440	97° 2' 57.214"	45° 57' 31.412"	2009
9	Олонбулаг-2а	Бигэр	0.05	450	97° 2' 50.572"	45° 57' 10.594"	2009
10	Олонбулаг -2b	Бигэр	1.37	12330	97° 2' 53.799"	45° 57' 7.867"	2009
11	Олонбулаг-3	Бигэр	0.76	7600	97° 3' 7.961" E	45° 57' 34.367"	2009
12	Олонбулаг -4	Бигэр	0.64	7680	97° 3' 12.635"	45° 57' 37.019"	2009
13	Олонбулаг -5	Бигэр	4.13	103250	97° 3' 32.950"	45° 57' 43.702"	2009
14	Олонбулаг -6а	Бигэр	0.07	770	97° 3' 32.778"	45° 57' 22.760"	2009
15	Олонбулаг -6b	Бигэр	0.53	5830	97° 3' 26.102"	45° 57' 24.035"	2009
16	Олонбулаг -7	Бигэр	2.87	3157	97° 3' 15.127"	45° 57' 23.609"	2009
17	Олонбулаг -8а	Бигэр	0.35	630	97° 3' 22.910"	45° 57' 15.712"	2009
18	Олонбулаг -8b	Бигэр	0.91	1638	97° 3' 15.174"	45° 57' 15.324"	2009
19	Олонбулаг -8с	Бигэр	0.10	180	97° 3' 34.800"	45° 57' 20.208"	2009
20	Олонбулаг- 1а	Бигэр	0.15	240	97° 2' 46.352"	45° 57' 24.195"	2009
21	Агуйт	Бигэр	11.00				2009
22	Гангат	Бигэр					2009
23	Баянсалаа	Бугат	4.43	79740	94° 13' 15.513"	45° 11' 52.850"	2009
24	Хар толгойн бэлчир	Бугат	0.39	3900	94° 12' 28.709"	45° 50' 40.505"	2020
25	Ялаатын гол	Есөнбулаг	0.69	5000	96° 9' 32.035"	46° 17' 7.347"	2010
26	Өлийн гол	Есөнбулаг	2.79	27000	96° 12' 45.563"	46° 15' 52.807"	2020
27	Ямаан усны ам	Есөнбулаг	5.11	102000	96° 44' 21.210"	46° 4' 7.983" N	2009
28	Ж амбий	Есөнбулаг	0.80	16000	96° 16' 27.784"	46° 17' 55.813"	2011
29	Суваргын ар сайр	Есөнбулаг	2.97	60000	96° 16' 55.187"	46° 18' 4.263"	2016
30	Зурх толгой	Есөнбулаг	6.76	136000	96° 17' 2.755"	46° 17' 48.154"	2016
31	Шаврын голын улаан хадны	Есөнбулаг	0.50				2021
32	Хөвийн ам-1	Тайшир	0.65	3924	96° 8' 34.771"	46° 30' 31.169"	2009
33	Хөвийн ам-2	Тайшир	1.06	6356.2	96° 8' 25.268"	46° 30' 30.534"	2009
34	Хөвийн ам-3	Тайшир	2.51	15032.1	96° 9' 18.121"	46° 30' 19.507"	2009
35	Хөвийн ам-5	Тайшир	0.43	2555.6	96° 9' 19.133"	46° 30' 34.511"	2009
36	Дөтийн даваа-1	Тайшир	13.27	159085.2	96° 25' 51.589"	46° 15' 15.699"	2006
37	Дөтийн даваа-2	Тайшир	5.38	64527.2	96° 25' 48.775"	46° 14' 46.702"	2006
38	Янчлын ам	Тайшир	0.33	3000	96° 9' 26.273"	46° 31' 35.488"	2018
39	Шар хоолой эвдэрсэн	Тонхил	1.51	45240	94° 6' 25.463"	45° 49' 41.343"	2000
40	Хөх сайр	Чандмань	32.99	1649500	98° 18' 27.543"	45° 35' 6.948"	2006
41	Хөх сайр	Чандмань	0.83	24000	98° 18' 27.543"	45° 35' 6.948"	2006
42	Цагаан толгойн огтрог	Цогт					2017
43	Дэлийн өвөр	Цогт					2017
44	Бага шанд-Шарга овоо	Шарга	2.64	39600	95° 43' 59.513"	46° 38' 20.954"	2010
45	Хөх хад-2	Шарга	0.04	720	95° 37' 29.122"	46° 30' 32.999"	2003
46	Цахир худаг-1	Шарга	0.44	6600	95° 43' 13.283"	46° 29' 28.149"	2003
47	Цахир худаг-2	Шарга	0.18	2700	95° 42' 52.034"	46° 29' 29.983"	2003
48	Хүрэн дэл	Шарга	33.53	502951.5	95° 42' 32.315"	46° 28' 35.148"	2009
49	Хөх хад-1	Шарга	0.60	9000	95° 37' 37.941"	46° 30' 38.201"	2003
50	Бударгант	Шарга	0.97	13500	95° 46' 8.076"	46° 27' 14.485"	2015
	50 нэгж талбар	9 сум	159.44	3580487			

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч



Аймгийн хэмжээнд 9 сумын 50 нэгж талбарын 159.4 га газарт хууль бус олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон байна.



3.4 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбай нь орон нутгийн тусгай хамгаалалтын газар болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилд давхцаж байгаа эсэх

3.4 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 42 талбайн 14,948.1 га нь усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилд давхцалтай, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 9 талбайн 33,269.5 га нь орон нутгийн тусгай хамгаалалтай газартай давхцалтай байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 42 талбайн 14,948.1 га нь усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилд давхцалтай байгаа тул хэмжилт судалгааны ажлыг газар дээр нь хийж шаардлагатай газруудад хасалт хийж усны мэдээллийн дэд санд оруулах ажил хийгдэж байна.



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Хүснэгт-12 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газрын давхцал

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар								давхцаж буй тусгай зөвшөөрөлтэй талбай						
№	газрын нэр	сум	нийт талбай	Зэрэглэл аймаг/сум	шийдвэрийн огноо	дугаар	хугацаа	№	ТЗ-н дугаар	талбайн нэр	нийт хэмжээ	олгосон огноо	давхцаж байгаа талбай /га/	Эзэмшигчийн нэр
1	Баянтоорой тосгоны нутаг дэвсгэр дэх отрын бүс нутаг	Цогт	92298.9	сумын ИТХ	2015.06.24	67	30	1	ХҮ-017846	Замт	8059.45	2015.07.07	8059.45	Хүрэмтийн хяр ХХК
								2	ХҮ-017881	Хүйс	1798.08	2015.09.03	1798	Ресурс партнерс ХХК
								3	ХҮ-017951	Хөх дэл	3686.12	2015.06.18	3248	Хан хэнтийн хүдэр ХХК
								4	ХҮ-017720	Хөх дэл	9362.75	2015.07.07	8533	Хүрэмтийн хяр ХХК
								5	ХҮ-018223	Сүүл	2495.42	2015.08.11	1719	Майн перлект сольюшн ХХК
2	Хөвчийн нуруу	Бугат	85270.5	сумын ИТХ	2017.05.08	16	15	6	ХҮ-018239	Алтанмандал	3979.03	2016.08.15	3259	Их очир мандал ресурс ХХК
3	Бичигт хад, Молор толгой	Бигэр	998.62	сумын ИТХ	2015.04.30	4	30	7	ХV-018741	Хүрэн уул	11248.06	2015.06.15	344	Домогт хээр ХХК
4	Улаансайрын хойд дэнжийн Хүн чулуу	Бигэр	1337.5	сумын ИТХ	2014.04.24		30	8					6085	Домогт хээр ХХК
5	Цахир булаг	Есөнбулаг	6899.39	Аймгийн ИТ	2015.12.04	16	50	9	МУ-021169	Замт	384.42	2018.09.19	224	Болдгянтболд ХХК
Нийт дүн													33,269.5	

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Цогт, Бугат, Бигэр, Есөнбулаг сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 9 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 33,269.5 га газартай давхцалтай байна. Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 62.1¹³, 62.3¹⁴, 62.4¹⁵, 11.1.23¹⁶-т заасны дагуу төрийн захиргааны байгууллага зөрчлийг арилгахаар байна.

3.5 Тусгай зөвшөөрөлтэй талбайд зориулалт бусаар ашиглалт, үйл ажиллагаа явуулсан эсэх.

3.5 Улсын нөөцөд авсан газраас зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал болон түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлож байна.

¹³ Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд үүссэн талбайн хилийн маргааныг төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

¹⁴ Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд тусгагдсан маргаантай талбайнууд хоорондоо ямар нэг байдлаар давхцаж байгаа эсэхийг шалгах бөгөөд давхцал байгаа нь тогтоогдвол тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн анхны өргөдөл болон талбайн хилийн хэмжилтийн тайланг үндэслэн талбайн хил, булангийн цэгийн солбицлууд зөв бүртгэгдсэн эсэхийг шалгана.

¹⁵ Хэмжилтийн дүнд давхцал байгаа нь тогтоогдвол төрийн захиргааны байгууллага сүүлд авсан тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд зохих өөрчлөлтийг оруулж, давхцалыг арилгана.

¹⁶ энэ хуулийн 12.1.5-д заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын гаргасан хүсэлтийг хүлээн авч сонгосон газар нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох



Аудитаар газар эзэмших, ашиглах эрхийн судалгаа хийхэд ашиглалтын 55 тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгж байгууллагаас 10 нэгж талбарт газар эзэмших эрх авсан байна.

Төгрөг сумын Хүрэн гол багийн Атгын ам, Бор энгэр нэртэй улсын нөөцийн газарт 2013 оноос хойш нутгийн болон хажуу зэргэлдээ сумын иргэд, аж ахуй нэгж байгууллага зөвшөөрөлгүйгээр нүүрс олборлосоор байгаа зөрчил байна. Иймд сумын удирдлага зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал олборлож байгаа үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэхээр байна.

Мөн аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох зөвшөөрөл олгогдоогүй байна. Сум орон нутагт барилга, байгууламж, зам, гүүр барихтай холбогдуулан элс, хайрга гэх мэт түгээмэл тархацтай ашигт малтмалын хэрэгцээ зайлшгүй гарч байгаа бөгөөд гүйцэтгэгч компани нь ашигт малтмалыг сумын нутаг дэвсгэрээс зөвшөөрөлгүйгээр олборлон авч байна.

ИЛРҮҮЛЭЛТ:

Нутгийн захиргааны байгууллагатай харьцах нийгмийн хариуцлагын гэрээний талаар:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллаагүй байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, нөөц ашигласны төлбөрийн талаар:

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нийт 1,599.6 мянган төгрөгийн зөвшөөрлийн төлбөр төлсөн нь тодорхойгүй байна.
3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалыг иргэн, хуулийн этгээдэд ашиглуулан орон нутгийн төсөвт 2018 онд 15,313.6 мянган төгрөгийн, 2019 онд 23,952.7 мянган төгрөгийн, 2020 онд 19,301.5 мянган төгрөгийн түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төвлөрүүлжээ.

Бичил уурхайн олборлолтын талаар:

4. Алтай сум нь зарим бичил уурхай эзэмшигчтэй гэрээ байгуулаагүй, зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлуулсан.
5. Алтай сумын бичил уурхай эзэмшигчдээр нөхөн сэргээлт хийсэн эсэх нь тодорхойгүй, нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн аваагүй.

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн талаар:

6. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 2018-2021 онд давхардсан тоогоор 397 нэгж талбарт хайгуул хийгээгүй, 306 лиценз эзэмшигч менежментийн төлөвлөгөө батлуулаагүй, менежментийн төлөвлөгөө батлуулснаас 87 лиценз эзэмшигч нь нөхөн сэргээлтийн тайлан ирүүлж дүгнүүлээгүй байна.
7. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлбэл зохих дүнгээс 10,381.0 мянган төгрөгийг дутуу, 4,775.0 мянган төгрөгийг илүү байршуулжээ.
8. Нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө батлуулаагүй боловч 25,510.0 мянган төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн дансанд байршуулсан.
9. Сумын Засаг дарга байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлахдаа баталгааны мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх хугацааг тогтоож өгөөгүйгээс болж дутуу байршуулсан мөнгөн хөрөнгөнд журмын дагуу алданги тооцоогүй байна.
10. 2018-2021 онд буцаан олговол зохих барьцаа хөрөнгөнөөс 64,140.0 мянган төгрөгийг олгоогүй байна. Үүнээс нөхөн сэргээлтийн мэдээ гаргаагүй, тайлан ирүүлээгүй 87 лиценз эзэмшигчийн 23,430.0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө байна. буцаан олговол зохих барьцаа хөрөнгөнөөс 64,140.0 мянган төгрөгийг олгоогүй байна. Үүнээс нөхөн сэргээлтийн мэдээ гаргаагүй, тайлан ирүүлээгүй 87 лиценз эзэмшигчийн 23,430.0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө байна.



11. Сум нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг нөхөн сэргээх баталгаа мөнгөн хөрөнгийг байршуулсан тухай санхүүгийн баримтыг тухай бүр авч баримтын бүрдэл болгоогүй, дансны хуулгыг архивлаж хадгалаагүй байна.
 12. Байгаль хамгаалах нөхөн сэргээх сангийн үлдэгдэл 187,226.2 мянган төгрөг байгаагаас нягтлан бодох бүртгэлд 117,197.9 мянган төгрөг өглөгөөр бүртгэж, 70,028.3 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг өглөгөөр бүртгээгүй байна.
 13. Жил бүр тусгай зөвшөөрөл эзэмшигчийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж байршуулсан мөнгөн хөрөнгийг буцааж өгөөгүйгээр өглөгийг нэмэгдүүлсэн төдийгүй 117,197.9 мянган төгрөгийн өглөг нь ямар компанид өгөх нь тодорхойгүй нягтлан бодох бүртгэлд бөөн дүнгээр бүртгэсэн байна.
 14. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байршуулсан мөнгөөр тооцож үзэхэд 187,226.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс хугацаа дууссан лиценз эзэмшигчийн байршуулсан 109,103.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.
 15. Бичил уурхай эрхлэгчдээс нөхөн сэргээлтийн санд төвлөрүүлсэн барьцаа хөрөнгөнөөс 2018-2021 онд зориулалт бусаар 34,238.8 мянган төгрөгийг зарцуулсан.
- Эвдэрсэн газрын талаар:**
16. Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн 6 сумын 18 нэгж талбарт 288.9 га газар байна.
 17. Аймгийн хэмжээнд 9 сумын 50 нэгж талбарын 159.4 га газарт хууль бус олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон байна.
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн давхцалын талаар:**
18. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 42 талбайн 14,948.1 га нь усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилд давхцалтай байна.
 19. Цогт, Бугат, Бигэр, Есөнбулаг сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 9 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 33,269.5 га газартай давхцалтай байна.
- Зөвшөөрөлгүйгээр олборлолт явуулж байгаа талаар:**
20. Төгрөг сумын Хүрэн гол багийн Атгын ам, Бор энгэр нэртэй улсын нөөцийн газарт 2013 оноос хойш нутгийн болон хажуу зэргэлдээ сумын иргэд, аж ахуй нэгж байгууллага зөвшөөрөлгүйгээр нүүрс олборлосоор байна.
 21. Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох зөвшөөрөл олгогдоогүй байна. Сум орон нутагт барилга, байгууламж, зам, гүүр барихтай холбогдуулан элс, хайрга гэх мэт түгээмэл тархацтай ашигт малтмалын хэрэгцээ зайлшгүй гарч байгаа бөгөөд гүйцэтгэгч компани нь ашигт малтмалыг сумын нутаг дэвсгэрээс зөвшөөрөлгүйгээр олборлон авч байна.

Ерөнхий Дүгнэлт

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ БИЙ БОЛГОН, БИЧИЛ УУРХАЙГ ДЭМЖИЖ, ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙГ ИРГЭДИЙН НӨХӨРЛӨЛИЙН ОРОЛЦООТОЙГООР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХЭЭР БАЙНА.

Дээрх дүгнэлтэд үндэслээд дараах шийдвэрийг гаргаж байна.

Зөвлөмж

Аймаг, сумдын Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч нарт:

1. Лиценз эзэмшигчидтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, биелэлтийг дүгнэж ажиллах
2. Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан лиценз эзэмшигчийн байршуулсан мөнгөн хөрөнгийг хууль эрх зүйд нийцүүлэн шийдвэрлэх
3. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх арга хэмжээг хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулах
4. Тусгай зөвшөөрөлтэй талбайн орон нутгийн тусгай хамгаалалттай газар болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн давхцалыг арилгах арга хэмжээ авах



Албан шаардлага

Аймаг, сумдын Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч нарт:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын зөвшөөрлийн төлбөрийг төлүүлж байх
2. Зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашиглаж байгаа зөрчлийг арилгах арга хэмжээг авч хуульд нийцүүлэн шийдвэрлэх
3. Бичил уурхайн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулж, нөхөн сэргээлтийг бүрэн хийлгүүлэх.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг жил бүр батлан, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг бүрэн байршуулж хэвших
5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол байршуулсан мөнгийг буцааж өгч байх
6. Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу, аккрузель сууриар хөтөлж, санхүүгийн баримт материал, төлбөрийн баримт, дансны хуулга, байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайланг хууль тогтоомжийн дагуу архивлах.
7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй тооцоо нийлж өглөгийг барагдуулах
8. Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01-р сарын 06-ны өдрийн 04 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам"-ыг баримталж ажиллах
9. Зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох



Холбогдох байгууллагын санал:

 ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠭᠣᠪᠤ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ	
82093 Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг Утас: 7048-4004, Факс: 7048-3360	
2021.06.29	№ 1/699
танай 2021.06.29	Ны № 327 -Т
ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ	
“Уул уурхайн ашигт малтмалын хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн хэрэгжилт”-д 2018-2021 оныг хамруулсан гүйцэтгэлийн аудитын тайланд санал байхгүй болно. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллана. Тайланд санал байхгүй бөгөөд энэ цаг үед Коронавирусын тархалт ихтэй байгаа тул хэлэлцүүлгийг цуцлахыг үүгээр мэдэгдье.	
 О.АМГАЛАНБААТАР	
0205000635	

